



“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу

САГ-ын захирал бөгөөд тэргүүлэх
аудитор
Ц.Наранчимэг
Утас:261663
Цахим хаяг:

naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас:261885
Цахим хаяг:
Sambuunyamyа@audit.gov.mn
Аудитор: Н.Нямдаваа
Утас:260512
Цахим
хаяг:Nyamdavaan@audit.gov.mn

Гүйцэтгэсэн:
Багийн ахлагч: П.Рэнцэнмядаг
Утас:99008641
Аудитор Н.Амгалан
Утас:86980030
Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх
дүүрэг, 4 дүгээр хороо АОС-21,
2 давхар

Цахим хаяг:
P_Rentsenmyadag@yahoo.com
Утас:451072, 99008641
Факс: 451072

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

2018 оны 3 дугаар сар



АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Материаллаг байдал
7. Байгууллагын орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагвар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар ирүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануулын талаарх тайлбар
13. Анхаарал татахуйц бусад чухад асуудлууд
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дах заалтуудыг үндэслэн Үндэсний аудитын газрын захиалгаар “Алтанжолоо Аудит” ХХК “Багануурын Дулааны станц” ТӨХК -ийн 2017 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийлээ. САГ/2018/3/СТА-ТӨҮГ

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлсэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Багануурын Дулааны станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн өмчит байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шудрага илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Багануурын Дулааны станц” ТӨХК-ийн удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төрийн өмчит байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шудрага илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Багануурын Дулааны станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 15-наас 2018 оны 03 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн аудитын багийн ахлагч захирал П.Рэнцэнмядаг, аудитор Н.Амгалан, С.Ганцацрал Д.Мягмарсүрэн нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-8/

“Алтанжолоо Аудит” ХХК нь аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 17-нд “Багануурын Дулааны станц” ТӨХК -ийн удирдлагад гардуулна.

2. Байгууллагын хууль эрх зүйн орчин:

“Багануурын Дулааны станц” ТӨХК нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, бусад хуулиудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон зарим заавар, журмыг мөрдөн ажиллаж байна. Мөн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2017 онд боловсруулан мөрдөн ажиллажээ.



3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Багануурын Дулааны станц” ТӨХК-ийн зорилтыг “... Хүний хөгжил, дэвшилтэт технологид түшиглэн үр ашигтай үйлдвэрлэл явуулж, стандартын шаардлага хангасан дулаан эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангана” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1. “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана. ...” гэж заасны дагуу “Багануурын Дулааны станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж байна.

Компанитай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад холбогдох хуулиудыг хэрэгжүүлэн ажиллажээ.

Энэ байгууллагын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Багануурын Дулааны станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд балансын дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5-3/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй дансанд түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 31 горим сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-А-7/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Багануурын Дулааны станц” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх болосвруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллажээ.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцаж, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “дунд” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Багануурын Дулааны станц” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн “Винеца” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна. /ТАБ-СТА-В-2/

5. Дотоод хяналт:

Санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Багануурын Дулааны станц” ТӨХК-ийн дотоод хяналт, эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянаж үзэхэд санхүүгийн зарим үйл ажиллагаанд дотоод хяналт хангалтгүй байна.

6. Материаллаг байдал:

Төлөвлөлтийн үед шинж чанар болон орчин нөхцлийн хувьд материалаг шинжтэй зүйлс илрээгүй ба эрсдэл “дунд” гэж үнэлсэн тул материалаг байдлын түвшинг өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,955.9 сая төгрөгийн 1% буюу 59.5 сая төгрөгөөр тогтоолоо. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тайлант оны нийт зардлын 5970.5 сая төгрөгийн 2% буюу 119.4 сая төгрөгөөр тооцлоо.

7. Байгууллагын орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:


2017 оны батлагдсан үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого, зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

“Багануурын Дулааны станц” ТӨХК 2017 онд борлуулалтын орлогоос 4,740.8 сая төгрөг байхаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр борлуулалтын орлогоос 4,836.4 сая, ЭХЯамнаас дулааны үнийн зөрүүнд 1,100.0 сая төгрөгийн санхүүжилт, туслах үйл ажиллагаанаас 138.8 сая, нийт 6,075.2 сая төгрөгийн орлоготой, өртөг, зардал гүйцэтгэлээр борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 5,656.9 сая, өрөнхий ба удирдлагын зардалд 299.1 сая, бусад зардалд 127.4 сая, нийт 6,083.4 сая төгрөгийг зарцуулж, 22.8 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Зорилтод түвшний биелэлтийг хавсралтаар гаргав.

8. Шилэн дансны мэдээлэл:

Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn цахим хуудсанд 2017 оны орлого, зардлын төлөвлөгөө, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг мэдээллийг байршуулсан байна.

9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагвар: Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 20 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан 25 горим, сорил гүйцэтгэв.



10. Гол онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Багануурын Дулааны станц ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний нийт 10,256.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, орлого, бусад орлого, авлага, томилолт, шатахуун, сэлбэг, шагнал, урамшуулал сургалт семинар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Эдгээр шалгасан нарийвчилсан горим, сорил нь тус байгууллагын нийт орлогын 70.0%, нийт зардлын 65.0%, нийт хөрөнгийн 20.0%-ийг тус тус эзэлж байна.

11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийн шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлыг дараах заалтанд хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох хууль, заавар, журмын заалтыг зөрчсөн **материаллаг бус** хэмжээний 69,6 сая төгрөгийн алдаа илэрсэн. Үүнд:

- Оны эхэнд авлагын үлдэгдэл 353.6 сая төгрөг байсан бөгөөд 126.8 сая төгрөг буюу 36 хувиар буурсан байна. Үүнээс санхүүгийн тайланд тусгагдсан “Эйч зэт эйч” ХХК-ийн 4.5 сая, “Саарал лупус” ХХК-ийн 4.9 сая, 2 болон түүнээс дээш жил болсон хувь хүн болон айл өрхөөс авах авлага 5.3 сая, нийт 14.7 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ аваагүй байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна

Шийдвэрлэсэн нь: Дээрх авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авах зөвлөмж өгсөн.

- Арилжааны банкин дахь /ХААН Банк, Хас банк, Төрийн банк, Капитал банк/ харилцах дансны ажил гүйлгээнүүдийг түүвэрлэн үзэхэд нэр, данс зөрүүтэй нийт 54.9 сая төгрөгийн дараахь гүйлгээнүүд гарсан байна. Үүнд: Харилцах данснаас өндөр насны тэтгэвэр Дамдинсүрэнгийн Эрдэнэбаатар 10.0 сая, Санжаагийн Октябр 4.3 сая, Голомт банкинд зээлийн төлбөрт 3.8 сая, НӨАТ-ын өглөг 11.2 сая, “Тэлүүн ач” ХХК-нд кондейшний үнэ 5.6 сая, “Өгөөмөр цэн” ХХК 20.0 сая, нийт 54.9 сая төгрөг.
- Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.
- Улсын хөрөнгө оруулалтаар хийгдсэн "Сүлжээний усны зарцуулалт хувьсах насосны горимд шилжих" ажлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын /ТӨБЗГ/ шийдвэр гараагүй байхад ТӨБЗГ-ын 2017 оны 7 дугаар сарын 5-ны 344 дүгээр тогтоол 3 098.7 сая төгрөгөөр орлогод авах шийдвэр гарсан.

Улсын комиссын 2015 оны 11 дүгээр сарын 30-ны 51/2015 дугаар актаар хүлээн авсан баримтыг үндэслэн 2016 онд 3 099.9 сая төгрөгөөр үндсэн хөрөнгөнд орлого авахдаа

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

ТӨБЗГ-ын шийдвэрээс 1.3 сая төгрөгөөр илүү үнээр авсан. Мөн 2017 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 937.6 сая төгрөгийн “Дулаан дамжуулах төв”-ийн барилгыг ТӨБЗГ-ын 2017 оны 491 дүгээр тогтоолоос 1.3 сая төгрөгөөр дутуу тооцож орлого авсан байна. Энэ нь 2016 онд үндсэн хөрөнгөнд илүү авсан үнийн зөрүүгийн залруулсантай холбоотой байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

- Санхүүгийн тайланд тусгагдсан хуримтлагдсан өр төлбөрийн 2,365.0 сая төгрөг буюу 82.4 гаруй хувийг байгууллага хоорондын тооцооны өглөг эзэлж байгаа бөгөөд үүнээс Багануур ХК-д өгөх нүүрсний хуримтлагдсан өглөг 1,950.3 сая төгрөг
- Энэ хуримтлагдсан өглөг нь цаасан дээр дулаан нийлүүлэлтийн борлуулалт, ус, нүүрсний худалдан авалтын зөрүү тооцоо Багануурын Дулааны станц ТӨХК-д очихгүй байна.
- Хэдийгээр 1 тн нүүрсний үнэ хямдарсан ч Багануур ХК-д дулаан нийлүүлж байгаа Багануур Дулааны станц ТӨХК-д борлуулалтын НӨАТ-ын асуудал ч гарч байна.
- Тус байгууллагад дээрх байгууллагаас орох мөнгөн хөрөнгийн орлого орохгүй байгаагаас бусад өр төлбөрийг барагдуулахад сөргөөр нөлөөлж байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах зөвлөмж өгсөн.

12. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Журам, заавар мөрдөөгүйгээс гарсан 69.6 сая төгрөгийн зөрчлийг залруулаагүй болно.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал байхгүй

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар зарим үндсэн хөрөнгөнд биет тест хэрэгжүүлээгүй болно. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг, зардал нь аудитын хамрах хүрээний асуудал боловч цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитын явцад түүвэрт хамруулан шалгаж амжаагүй дээрх асуудлыг 2018 оны завсрын аудитаар нөхөн шалгах болно.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл:



Тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 70,9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 1.3 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийсэн байна, 69.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

“Багануурын Дулааны станц” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК аудит хийж 6 зөвлөмж өгснөөс 100%-ийг хэрэгжүүлжээ.

17. Зөрчилгүй санал дүгнэлт:

“Багануурын Дулааны станц” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шудрага илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 7 хуудас, менежментийн захидал 6 хуудсыг тус тус хавсаргав.

БЭЛТГЭСЭН:

АЛТАН ЖОЛОО АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

АУДИТОР

П.РЭНЦЭНМЯДАГ

Н.АМГАЛАН

2018 оны 3 дугаар сарын 6





“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу

САГ-ын захирал бөгөөд тэргүүлэх
аудитор
Ц.Наранчимэг
Утас:261663
Цахим хаяг:

naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас:261885
Цахим хаяг:
Sambuunyamyа@audit.gov.mn
Аудитор: Н.Нямдаваа
Утас:260512
Цахим
хаяг:Nyamdavaan@audit.gov.mn

Гүйцэтгэсэн:
Багийн ахлагч: П.Рэнцэнмядаг
Утас:99008641
Аудитор Н.Амгалан
Утас:86980030
Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх
дүүрэг, 4 дүгээр хороо АОС-21,
2 давхар
Цахим хаяг:
P_Rentsenmyadag@yahoo.com
Утас:451072, 99008641
Факс: 451072

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №01

Хавсралт 1: Дансны авлага

Хавсралт 2: Мөнгөн хөрөнгө

Хавсралт 3: Үндсэн хөрөнгө

Хавсралт 4: Хуримтлагдсан өр төлбөр

Хавсралт 5: Бусад

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2018 оны 3 дугаар сар

Менежментийн захидал

Алтанжолоо Аудит ХХК нь аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Багануурын Дулааны станц” ТӨХК-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлыг агуулга АОУС-ын дагуу хийгддэг ҮАГ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжүүдийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Багануурын Дулааны станц” ТӨХК-ийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Асуудал 1: Дансны авлага

Тэргүүлэх ач холбогдол №1

Ажиглалт

- Санхүүгийн тайланд тусгагдсан “Эйч зэт эйч” ХХК-ийн 4.5 сая, “Саарал лупус” ХХК-ийн 4.9 сая, 2 жил болсон хувь хүн болон айл өрхөөс авах авлагын үлдэгдэл 5.3 сая, нийт 14.7 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ аваагүй байна.

Эрсдэлүүд

- Дансны авлагын үлдэгдлийг барагдуулаагүй, насжилтаар ангилан бүртгээгүй байх;
- Холбогдох хууль, заавар, журам зөрчигдөх. Э-2

Зөвлөмж

- Дансны авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 10 сарын 01-ны дотор ҮАГ-т ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

- Байгууллагын удирдлагын зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах тухай хариу ирүүлсэн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Асуудал 2: Мөнгөн хөрөнгө

Тэргүүлэх ач холбогдол №2

Ажиглалт

- Арилжааны банкин дахь /ХААН Банк, Хас банк, Төрийн банк, Капитал банк/ харилцах дансны ажил гүйлгээнүүдийг түүвэрлэн үзэхэд нэр, данс зөрүүтэй нийт 54.9 сая төгрөгийн дараахь гүйлгээнүүд гарсан байна. Үүнд: Харилцах данснаас өндөр насны тэтгэвэр Дамдинсүрэнгийн Эрдэнэбаатар 10.0 сая, Санжаагийн Октябрь 4.3 сая, Голомт банкинд зээлийн төлбөрт 3.8 сая, НӨАТ-ын өглөг 11.2 сая, “Тэлүүн ач” ХХК-нд кондейшний үнэ 5.6 сая, “Өгөөмөр цэн” ХХК 20.0 сая, нийт 54.9 сая төгрөг.

Зөвлөмж

- Харилцах дансны ажил гүйлгээний анхан шатны баримтыг үнэн зөв үндэслэж байх ;
- **Дээрх зөвлөмжийн талаар ямар ажил зохиож ажиллаж байгаа талаар болон, биелэлтийг 2018 оны 12 сарын 25-ны дотор ҮАГ-т ирүүлэх.**

Эрсдэлүүд

- Харилцах дансны ажил гүйлгээг хийхдээ анхан шатны баримтыг үндэслээгүй байх;

Үйлчлүүлэгчийн хариу

- Байгууллагын удирдлагын зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах тухай хариу ирүүлсэн болно.

Асуудал 3: Үндсэн хөрөнгө

Тэргүүлэх ач холбогдол №2

Ажиглалт

Улсын хөрөнгө оруулалтаар хийгдсэн "Сүлжээний усны зарцуулалт хувьсах насосны горимд шилжих" ажлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын /ТӨБЗГ/ шийдвэр гараагүй байхад /ТӨБЗГ-ын 2017 оны 7 дугаар сарын 5-ны 344 дугаар тогтоол 3 098.7 сая төгрөгөөр орлогод авах шийдвэр гарсан./ улсын комиссын 2015 оны 11 дүгээр сарын 30-ний 51/2015 дугаар актаар хүлээн авсан баримтыг үндэслэн 2016 онд 3 099.9 сая төгрөгөөр үндсэн хөрөнгөнд орлого авахдаа ТӨБЗГ-ын шийдвэрээс 1.3 сая төгрөгөөр илүү үнээр авсан. Мөн 2017 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 937.6 сая төгрөгийн "Дулаан дамжуулах төв"-н барилгыг ТӨБЗГ-ын 2017 оны 491 дүгээр тогтоолоос 1.3 сая төгрөгөөр дутуу тооцож орлого авсан байна. Энэ нь 2016 онд үндсэн хөрөнгөнд илүү авсан үнийн зөрүүгийн залруулсантай холбоотой байна.

Эрсдэлүүд

- Үндсэн хөрөнгийг холбогдох заавар, журмын дагуу бэлтгээгүй байх;

Зөвлөмж

- Үндсэн хөрөнгийг холбогдох хууль, заавар, журмын дагуу орлого авч байх;
- Холбогдох байгууллагын шийдвэрийг цаг тухай бүрд нь авч үнэн зөв бүртгэж хэвших. Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 12 сарын 25-ны дотор ҮАГ-т ирүүлэх бөгөөд тайлант жилд үндсэн хөрөнгийн хөдөлгөөний талаар холбогдох баримтыг ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

- Байгууллагын удирдлагын зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах тухай хариу ирүүлсэн болно.

Асуудал 4: Хуримтлагдсан өр төлбөр

Тэргүүлэх ач холбогдол №2

Ажиглалт

- Өглөгийн 2, 365.0 сая төгрөг буюу 82.4 гаруй хувийг байгууллага хоорондын тооцооны өглөг эзэлж байгаа бөгөөд үүнээс Багануур ХК-нд өгөх нүүрсний хуримтлагдсан өглөг 1, 950.3 сая төгрөг
- Энэ хуримтлагдсан өглөг нь цаасан дээр дулаан нийлүүлэлтийн борлуулалт, ус, нүүрсний худалдан авалтын зөрүү тооцоо Багануур Дулааны станц ТӨХК -ианд очихгүй байна.
- Хэдийгээр 1 тн нүүрсний үнэ хямдарсан ч Багануур ХК-нд дулаан нийлүүлж байгаа Багануур Дулааны станц ТӨААТҮГ-т борлуулалтын НӨАТ – ын асуудал ч гарч байна.

Тус байгууллагад дээрх байгууллагаас орох мөнгөн хөрөнгийн орлого орохгүй байгаагаас бусад өр төлбөрийг барагдуулахад сөргөөр нөлөөлж байна.

Эрсдэлүүд

- Хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах дансны бичилтийг буруу хийсэн байх;
- Өр төлбөрийг барагдуулаагүй байх;

Зөвлөмж

- Хуримтлагдсан өр төлбөрийг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 10 сарын 01-ны дотор ҮАГ-т ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

- Байгууллагын удирдлагын зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах тухай хариу ирүүлсэн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Асуудал 5: Бусад

Тэргүүлэх ач холбогдол №2

Ажиглалт

- Дотоод хяналтын ажилтны орон тоонд санхүүгийн мэргэжлийн бус хүн авч ажиллуулсан.

Зөвлөмж

- Дотоод хяналтын ажилтны орон тоонд санхүүгийн мэргэжлийн хүн авч ажиллуулах шаардлагатай. **Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 04 сарын 15-ны дотор ҮАГ-т ирүүлэх.**

Эрсдэлүүд

- Дотоод хяналтын ажилтнаар санхүүгийн мэргэжлийн бус хүн ажиллуулсан байх;

Үйлчлүүлэгчийн хариу

- Байгууллагын удирдлагын зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах тухай хариу ирүүлсэн болно.

БЭЛТГЭСЭН:

АЛТАН ЖОЛОО АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

АУДИТОР

П.РЭНЦЭНМЯДАГ

Н.АМГАЛАН


2018 оны 3 дугаар сар



АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ	0,00	0,00
Эргэлтийн хөрөнгө	0,00	0,00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	11 160 694,73	20 560 282,88
Дансны авлага	342 472 135,19	277 155 287,28
Татвар, НДШ – ийн авлага	0,00	0,00
Бусад авлага	11 143 020,97	50 374 093,13
Бусад санхүүгийн хөрөнгө	0,00	0,00
Бараа материал	221 649 360,88	188 285 112,26
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	719 999,99	0,00
Бусад эргэлтийн хөрөнгө	0,00	0,00
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0,00	0,00
	0,00	0,00
Эргэлтийн хөрөнгийн дүн	587 145 211,76	536 374 775,55
Эргэлтийн бус хөрөнгө	0,0	0,0
Үндсэн хөрөнгө	9 754 760 069,37	10 123 760 826,05
Биет бус хөрөнгө	0,0	0,0
Биологийн хөрөнгө	0,0	0,0
Урт хугацаат хөрөнгө оруулалт	0,0	0,0
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0,0	0,0
Хойшлогдсон татварын хөрөнгө	0,0	0,0
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0,0	0,0
Бусад эргэлтийн бус хөрөнгө	0,0	0,0
	0,0	0,0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	9 754 760 069,37	10 123 760 826,05
Нийт хөрөнгийн дүн	10 341 905 281,13	10 660 135 601,60
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0,00	0,00
ӨР ТӨЛБӨР	0,00	0,00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0,00	0,00
Дансны өглөг	3 127 065 071,58	2 310 701 387,89
Цалингийн өглөг	0,00	0,00
Татварын өр	55 412 551,30	207 441 134,00
НДШ - ийн өглөг	0,00	21 152 701,66
Богино хугацаат зээл	300 000 000,00	300 000 000,00
Хүүний өглөг	0,00	0,00
Ногдол ашгийн өглөг	0,00	0,00
Урьдчилж орсон орлого	3 245 241,72	0,00
Нөөц /өр төлбөр/	0,00	0,00
Бусад богино хугацаат өр төлбөр	4 735 200,00	54 324 800,00
Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	0,00	0,00
	0,00	0,00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	3 490 458 064,60	2 893 620 023,55
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0,00	0,00
Урт хугацаат зээл	0,00	0,00
Нөөц /өр төлбөр/	0,00	0,00
Хойшлогдсон татварын өр	15 293 567,00	16 987 636,18




“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бусад урт хугацаат өр төлбөр	0,00	0,00
	0,00	0,00
Урт хугацаат өр төлбөрийн дүн	15 293 567,00	16 937 636,18
Өр төлбөрийн нийт дүн	3 505 751 631,60	2 910 557 659,73
ЭЗДИЙН ӨМЧ	0,00	0,00
Өмч		
-төрийн	6 291 517 841,35	6 291 517 841,35
-хувийн	0,00	0,00
-хувьцаат	0,00	0,00
Халаасны хувьцаа	0,00	0,00
Нэмж төлөгдсөн капитал	0,00	0,00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	697 879 621,79	697 879 621,79
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0,00	0,00
Эздийн өмчийн бусад хэсэг	6 643 225 708,12	7 579 468 562,12
Хуримтлагдсан ашиг	-6 796 469 521,73	-6 819 288 083,39
Тайлангийн үеийн ашиг		-22 818 561,66
Өмнөх үеийн ашиг	-6 796 469 521,73	-6 796 469 521,73
	0,00	0,00
Эздийн өмчийн дүн	6 836 153 649,53	7 749 577 941,87
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	10 341 905 281,13	10 660 135 601,60

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	4 505 054 622,75	4 836 420 142,96
Борлуулалтын өртөг	5 705 088 101,32	5 656 915 740,29
Нийт ашиг (алдагдал)	-1 200 033 478,57	-820 495 597,33
Түрээсийн орлого	1 525 524,00	4 243 200,00
Хүүний орлого	1 015 239,50	779 893,50
Ногдол ашгийн орлого	0,00	0,00
Эрхийн шимтгэлийн орлого	0,00	0,00
Бусад орлого	1 214 400 903,62	1 233 738 913,21
Орлогын дүн	1 216 941 667,12	1 238 762 006,71
Борлуулалт, маркетингийн зардал	0,00	0,00
Ерөнхий ба удирдлагын зардал	208 022 438,83	220 271 903,23
Санхүүгийн зардал	65 722 138,80	78 788 251,40
Бусад зардал	0,00	0,00
Зардлын дүн	273 744 577,63	299 060 154,63
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0,00	0,00
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0,00	0,00
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0,00	0,00
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0,00	0,00
Бусад ашиг (алдагдал)	-116 574 507,97	-127 406 275,02
Олз, гарзын дүн	-116 574 507,97	-127 406 275,02
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-373 410 897,05	-8 200 020,27
Орлогын татварын зардал	1 109 170,34	14 618 541,39
Татварын дараахь ашиг (алдагдал)	-374 520 067,39	-22 818 561,66
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0,00	0,00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-374 520 067,39	-22 818 561,66
Бусад дэлгэрэнгүй орлого	0,00	0,00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0,00	0,00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0,00	0,00
Бусад олз (гарз)	0,00	0,00




Орлогын нийт дүн	-374 520 067,39	-22 818 561,66
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0,00	0,00

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0,00	0,00
Мөнгөн орлогын дүн	4 468 730 060,05	5 022 682 374,03
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3 329 212 473,42	3 634 792 075,69
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0,00	0,00
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	24 635 897,00	17 855 427,00
Буцаан авсан албан татвар	0,00	0,00
Татаас, санхүүжилтийн орлого	1 100 000 000,00	1 100 000 000,00
Бусад мөнгөн орлого	14 881 689,63	270 034 871,34
Мөнгөн зарлагын дүн	4 337 455 002,41	4 583 992 875,38
Ажиллагчдад төлсөн	1 470 193 958,23	1 595 810 508,10
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	424 755 746,03	403 514 592,00
Бараа материал худалдан авахад төлсөн	914 952 443,16	249 552 175,82
Ашиглалтын зардалд төлсөн	460 447 300,00	1 115 405 429,07
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	178 249 463,41	239 144 075,98
Хүүний төлбөрт төлсөн	60 816 738,80	57 578 887,76
Татварын байгууллагад төлсөн	465 578 355,05	456 432 985,00
Даатгалын төлбөрт төлсөн	1 953 000,00	4 526 716,15
Бусад мөнгөн зарлага	360 507 997,73	462 027 505,50
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	131 275 057,64	438 689 498,65
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0,00	0,00
Мөнгөн орлогын дүн	1 015 239,50	779 893,50
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0,00	0,00
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0,00	0,00
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0,00	0,00
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0,00	0,00
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0,00	0,00
Хүлээн авсан хүүний орлого	1 015 239,50	779 893,50
Хүлээн авсан ногдол ашиг	0,00	0,00
Мөнгөн зарлагын дүн	-175 638 100,00	-430 073 004,00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-175 638 100,00	-430 073 004,00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0,00	0,00
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0,00	0,00
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0,00	0,00
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0,00	0,00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-174 622 860,50	-429 293 110,50
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0,00	0,00
Мөнгөн орлогын дүн	391 340 500,00	350 000 000,00
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	391 340 500,00	350 000 000,00
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0,00	0,00
Төрөл бүрийн хандив	0,00	0,00



“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөнгөн зарлагын дүн	-341 340 500,00	-350 000 000,00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-341 340 500,00	-350 000 000,00
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0,00	0,00
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0,00	0,00
Төлсөн ногдол ашиг	0,00	0,00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	50 000 000,00	0,00
Валютын ханшийн зөрүү	0,00	0,00
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	6 652 197,14	9 399 588,15
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	4 508 497,59	11 160 694,73
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	11 160 694,73	20 560 282,88



АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2015 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	6 291 517 841,35	0,00	0,00	697 879 621,79	0,00	3 543 230 021,00	-6 421 949 454,34	4 110 678 029,92
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00
Залруулсан үлдэгдэл	6 291 517 841,35	0,00	0,00	697 879 621,79	0,00	3 543 230 021,00	-6 421 949 454,34	4 110 678 029,92
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00	-374 520 067,39	-374 520 067,39
Өмчид гарсан өөрчлөлт	0,00	0,00	0,00	0,00	0,00	3 099 995 687,00	0,00	3 099 995 678,00
Зарласан ногдол ашиг	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00
2016 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	6 291 517 841,35	0,00	0,00	697 879 621,79	0,00	6 643 225 708,00	-6 796 469 521,73	6 836 153 649,53
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00
Залруулсан үлдэгдэл	6 291 517 841,35	0,00	0,00	697 879 621,79	0,00	6 643 225 708,00	-6 796 469 521,73	6 836 153 649,53
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00	-22 818 561,66	-22 818 561,66
Өмчид гарсан өөрчлөлт	0,00	0,00	0,00	0,00	0,00	936 242 854,00	0,00	936 242 854,00
Зарласан ногдол ашиг	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00
2017 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	6 291 517 841,35	0,00	0,00	697 879 621,79	0,00	7 579 468 562,00	-6 819 288 083,39	7 749 577 941,87



01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

